



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrt.d.gov.mn, http://www.mrt.d.gov.mn

2022.05.03 № 03/2013
танай _____-ны № _____-т

「САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН」
ГАЗАРТ

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршиж байгаа үлдэгдлээс хавсралтад заасан “Эн Би Си Си” ХХК-д гэрээний дагуу олгох 18,285,000.0 (арван найман сая хоёр зуун наян таван мянга) төгрөгийн эрхийг зохих журмын дагуу нээж өгнө үү.

Хавсралт.....²⁴ хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД



080001578

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах даннаас барьцаа хөрөнгө олгох жагсаалт

2022.04.28

/төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	2021 оны эхний үлдэгдэл	2021 онд нэмэгдсэн орлого	2021 онд олгосон дүн	Одоо олгох дүн	Үлдэгдэл	Гэрээний заалт	Шийдвэр
	Эрх нээлгэх нийт дүн		18,285,000.0	0.0	0.0	18,285,000.0	0.0		
1	Дөрвөлжин-сархайрхан 159 км замын зураг	"Эн Би Си Си" ХХК	18,285,000.00			18,285,000.0	0.0	Тусгай нөхцлийн 7.4.(4). Барилгын улаан шугам хүлээлцэх үед зураг төслөөс шалтгаалсан зөрчил гологдол үүсээгүйг гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн, эсхүл барилгын ажил эхлэлгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд энэхүү гэрээнд үндэслэн Зөвлөхөд олгоно.	2013.01.08-ны өдрийн 29/2013 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлт, 2012.10.18-ны өдрийн Зураг төсөл хүлээлцсэн акт,

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн дарга

Боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн шинжээч



Д.Гэрэлням

Ч.Ренчиндамба

Н.Баярсайхан



БАТЛАВ

САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Монгол Улсын Хөгжлийн
банкны Гүйцэтгэх захирал



КИМ ЖАНГ ЖИН

ЗАХИАЛАГЧ

Зам, Тээвэр, Барилга, Хот
байгуулалтын яамны төрийн
нарийн бичгийн дарга бөгөөд
төсвийн ерөнхий менежер

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ЗӨВЛӨХ

"Эн Би Си Си" ХХК-ийн
захирал



О.ЛИНЗОРИГ

I. ГЭРЭЭ

**ДӨРВӨЛЖИН - САРХАЙРХАН ЧИГЛЭЛИЙН 159 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО
ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

Дугаар №

2012 оны...05 сарын...04-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас *Зам, Тээвэр, Барилга, Хот байгуулалтын яам* (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "*Эн Би Си Си*" ХХК (цаашид "Зөвлөх" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2012 оны 05 дугаар сарын 04-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "Гэрээ" гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1-д тодорхойлсон "Техникийн даалгавар"-т заасан зөвлөх үйлчилгээг (цаашид "үйлчилгээ" гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь Захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь *Дөрвөлжин-Сархайрхан чиглэлийн 159 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, дугаар №.....-г* (цаашид "ажил" гэх) 365 700 000 ₮ (*Турван зуун жаран таван сая долоон зуун мянган төгрөг*) (цаашид "гэрээний үнэ" гэх) үйлчилгээг үзүүлэхээр Зөвлөхийн ирүүлсэн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт

Хавсралт №1 Техникийн даалгавар

Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь

Хавсралт №3 Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь

Хавсралт №4 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг

Хавсралт №5 Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, байгууламж

Хавсралт №6 Зөвлөхийн түншлэлийн гэрээ

Хавсралт №7 Гэрээний хэлцэл хийсэн тэмдэглэл



Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч, Санхүүжүүлэгч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Зөвлөх нь гэрээний дагуу Санхүүжүүлэгчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн гэрээнд заасан үйлчилгээг гүйцэтгэж, зөрчил, доголдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, доголдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

Гэрээтэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг талууд дараахь албан ёсны хаягаар албан бичгээр хүргүүлнэ

**САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ**

Монгол Улсын Хөгжлийн
банкны Зээлийн газрын
захирал
МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК
ХХК
ЧОЙ ЖОНГ КУУК

Хаяг:
Засгийн Газрын II байр
Нэгдсэн Үндэстний гудамж 5/
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар 15160
Монгол Улс
Утас: +976-70-130216
Факс: +976-70-130602

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ**

Зам Тээвэр, Барилга, Хот
байгуулалтын яамны Санхүү
хөрөнгө оруулалтын газрын
дарга
Г.МӨНХБИЛЭГ

Зам, Тээвэр, Барилга, Хот
байгуулалтын яамны Сайдын
багцын ерөнхий нягтлан
бодогч

Д.ДОЛГОРСҮРЭН

АЗГ-ын аргаар дарга

Р.ОНОН

АЗГ-ын СШННТХ-ийн
секторын эрхлэгч

Я.БАЯРХҮҮ

Хаяг: УБ хот ЧД,
Барилгачдын талбай 3,
Утас: 31-06-12,
Факс: (976-11)32-29-04

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ**

“Эн Би Си Си” ХХК-ий ерөнхий
инженер

С.ГАНХУЯГ

Хаяг: Улаанбаатар хот БЗД, 26-р
хороо, Их Монгол Улсын гудамж,
Баянмонгол хороолол 414-Е04
Утас: 976-77110033,
Факс: 976-77110333



III. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөнө.
1.4	Гэрээний баримт бичгүүд нь <i>Монгол</i> хэл дээр байна.
1.6	<p>Хаяг:</p> <p>Санхүүжүүлэгч : <i>Монгол Улсын Хөгжлийн банк</i> Санхүүжүүлэгчийн хаяг: <i>Засгийн Газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол Улс</i></p> <p>Харилцах хүн : <i>О. Оч, Зээлийн газрын мэргэжилтэн</i> Утас : <i>(976)70130516</i> Факс : <i>(976)70130602</i></p> <p>Захиалагч: <i>Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам</i> Захиалагчийн хаяг : <i>УБ хот ЧД, Барилгачдын талбай 3, Утас: 31-06-12, факс:(976-11)32-29-04</i></p> <p>Харилцах хүн : <i>Р.Онон, АЗГ-ын орлогч дарга</i> Утас : <i>976-11-326343</i> Факс : <i>976-11-310503</i></p> <p>Зөвлөхийн хаяг : <i>УБ хот, БЗД, 26-р хороо, Их Монгол Улсын гудамж, Баянмонгол хороолол 414-Е04</i></p> <p>Зөвлөх: <i>"Эн Би Си Си" ХХК</i> Харилцах хүн : <i>О.Чинзориг</i> Утас : <i>976-77110033</i> Факс : <i>976-77110333</i></p>
1.9	<p>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:</p> <p>Захиалагчийн: <i>Р.Онон, АЗГ-ын орлогч дарга</i></p> <p>Санхүүжүүлэгчийн: <i>Ц.Лут-Очир, Төслийн санхүүжилтийн хэлтсийн захирал</i></p> <p>Зөвлөхийн: <i>С.Ганхуяг, "Эн Би Си Си" ХХК-ийн ерөнхий инженер</i></p>
2.2	Тогтоосон хугацаа: <i>7 хоног</i>
2.3	Тогтоосон хугацаа: <i>105 хоног</i>
2.3	Зөвлөх нь эцсийн тайланг улсын экспертизээр батлуулан Захиалагчид хүлээлгэн өгснөөр энэхүү гэрээ дуусгавар болно. Гэрээ дуусгавар болох нь Гэрээний 7.4 заасан үүргээс чөлөөлөгдөх нөхцөл болохгүй.
3.1	<p>(1) Энэхүү гэрээний салшгүй хэсэг болох "Техникийн даалгавар"-ыг бүрэн хангасан инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулж Захиалагчид хүлээлгэж өгнө:</p> <p>(2) Зөвлөх нь Монгол улсын хэмжээнд болон олон улсад мөрдөж буй зураг төслийн ажлын стандарт, "Техникийн даалгавар"-т заасан норм, дүрмүүдийг дагаж мөрдөнө.</p> <p>(3) Зөвлөх нь зам барилгын ажлын тоо хэмжээ, нэгдсэн төсөв, төсөвт өртгийн</p>



	<p>хэмжээг нууцлан хадгалах ба бусдад мэдээлэхгүй;</p> <p>(4) Зам барилгын ажлыг гүйцэтгэх явцад Зөвлөхийн боловсруулсан зураг төслөөс шалтгаалан гарсан аливаа алдаа дутагдалыг өөрийн хөрөнгөөр Захиалагчийн заасан хугацаанд засах бөгөөд үүнээс үүсэх эрсдэлийг хүлээнэ;</p> <p>(5) Зураг төсөл боловсруулах ажлын Зөвлөх нь зам барилгын ажил эхлэхэд өөрийн зардлаар зам барилгын ажлын гүйцэтгэгчид улаан шугам хүлээлгэн өгч, акт үйлдэн Захиалагчид хүлээлгэн өгнө;</p> <p>(6) Зөвлөх нь инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг мэргэжлийн болон ёс суртахууны өндөр түвшинд, үнэнч шударгаар чанартай хийх үүрэгтэй;</p> <p>(7) Зөвлөх нь боловсруулсан инженерийн нарийвчилсан зураг төслийг Улсын экспертизээр баталгаажуулан захиалагчид ирүүлэх бөгөөд ажил хүлээлцсэн акт үйлдсэн байна.</p>
3.5	Зөвлөх нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна. Гэрээнд гарын үсэг зурснаас 14 хоногын дотор даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагч, санхүүжүүлэгчид ирүүлнэ. Хэрэв Зөвлөх энэ хугацаанд даатгалын гэрээг байгуулаагүй бол Санхүүжүүлэгч даатгалын гэрээг Зөвлөхийн өмнөөс хийж, гарсан зардлыг Зөвлөхд төлөх төлбөрөөс хасч тооцно.
3.7 (3)	Гэрээний бусад нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд.
3.8	Алданги ноогдуулах: <i>Хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн 0.25 хувийн алданги ноогдуулна. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэх тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авна.</i>
4.6	Төслийн удирдагч нь төслийн хугацаанд Монгол улсад байрлан үйл ажиллагаа явуулна.
5.1(7)	Захиалагчийн зүгээс Зөвлөхөд доорхи бусад дэмжлэг, тусламжийг үзүүлнэ. Үүнд: <i>Захиалагч нь зураг төслийг боловсруулахад шаардагдах техникийн нөхцлийг бүрдүүлэх, техникийн нөхцөлд тодруулга оруулах, зураг төслийг Улаанбаатар хотын харъяа байгууллагуудаар хянуулах, зөвшөөрөлцөхөд Зөвлөхд тусламж дэмжлэг үзүүлж хамтран ажиллана. Захиалагчийн зүгээс шугам сүлжээний агентлагуудад албан тоотоор хандаж техникийн нөхцлийг хүснэ. Үүний дагуу Зөвлөх болон туслан гүйцэтгэгч нь шугам сүлжээний агентлагтай зөвшилцөж, техникийн нөхцлийг гаргуулж авна. Шугам сүлжээний зураг төсөл боловсруулах зөвлөхүүд нь бие даан шаардлагатай зураг төслийг боловсруулж, улмаар тухайн шугам сүлжээний агентлагт хандаж зөвшилцөн батлуулах байдлаар ажлын зургийг иж бүрэн боловсруулах үүрэгтэй. Шугам сүлжээ, геологийн бүх ажил тусдаа экспертизээр орж баталгаажна.</i>
7.1(2)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: 365 700 000 ₮ (Гурван зуун жаран таван сая долоон зуун мянган төгрөг)
7.2	Нэмэлт ажлын хөлс, нөхөн төлбөрийг Захиалагч улсын төсөвт тусгана. Гэрээний үнээс нэмэгдсэн зардалд Санхүүжүүлэгч хариуцлага хүлээхгүй.
7.3	Гэрээний дагуу бүх төлбөр нь төгрөгөөр хийгдэнэ.
7.4(1)	<p>(1) Урьдчилгаа төлбөр: гэрээний үнийн 30% -тай тэнцэх урьдчилгаа төлбөрийг түүнтэй тэнцэх Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан тохиолдолд олгоно.</p> <p>(2) Нийт ажлын геодези, геологийн судалгаа хийж, Байр зүйн зураглал, Трассын сонголт төлөвлөлт, Гүүрийн төлөвлөлтийн тайланг Захиалагчаар батлуулан Санхүүжүүлэгчид хүргүүлэхэд 30 хувьтай тэнцэх дүнг олгоно. (Урьдчилгаа</p>



	<p>төлбөр төлсөн тохиолдолд 20% байна)</p> <p>(3) Бусад шугам сүлжээг төлөвлөн, Ажлын зургийн сүүлийн зөвшилцөл хийж, иж бүрэн зураг төсөвийг Улсын экспертизээр батлуулвал 65 хувьтай тэнцэх дүнг олгоно. Энэ нь сүүлчийн төлбөр болно. (Урьдчилгаа төлбөр төлсөн тохиолдолд 45% байх бөгөөд Урьдчилгаа төлбөрийн баталгааг Зөвлөхөд буцаана.)</p> <p>(4) Нийт төсөвт өртгийн 5 хувьтай тэнцэх дүнг тухайн зам барилгын ажил эхлэн улаан шугам хүлээлцэхэд зураг төслөөс шалтгаалсан зөрчил доголдол үүсээгүйг Барилгын ажлын гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн эсхүл барилгын ажил эхлэлгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд энэхүү гэрээнд үндэслэн Зөвлөхөд олгоно.</p>
7.4(4)	<p>Төлбөр хийх данс: <u>3600000028</u></p>



Дууриг



ГЭРЭЭТ ЗУРАГ ТӨСЛИЙН АЖИЛ ХҮЛЭЭЛГЭН
ӨГСӨН ТУХАЙ АКТ №01/2012

2012 оны 10 сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Захиалагч Зам тээврийн яам, Санхүүжүүлэгч Монгол улсын Хөгжлийн банк, Гүйцэтгэгч зам гүүрийн зураг төслийн “Эн Би Си Си” ХХК-ний хооронд байгуулсан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэрээгээр харилцан үүрэг хүлээж гүйцэтгэсэн “Дөрвөлжин /Эрдэнэхайрхан/ – Сархайрхан чиглэлийн 160.2км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл”-ийг Улсын экспертизээр шалгуулан хүлээлгэн өгөв.

Үүнд:

- | | |
|---|-------------------------------------|
| • Ажлын зураг /иж бүрдэл / | 4% (28 дэвтэр) |
| • Тайлбар бичиг | 4% (4 дэвтэр) |
| • Техникийн шаардлага | 4% (4 дэвтэр) |
| • Хучилтын тооцоо | 4% (4 дэвтэр) |
| • Ус өнгөрөөх байгууламжийн тооцоо, судалгааны тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Архилогийн тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Инженер геологийн судалгаа | 4% (24 дэвтэр) |
| • Геодизийн тайлан | 4% (8 дэвтэр) |
| • Байгаль орчны үнэлгээний тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Барилгын ажлын төсөв | 1% (1 дэвтэр) битүүмжилсэн байдлаар |
| • CD | 2% |

ХҮЛЭЭН АВСАН:

Зам, тээврийн яамны АЗБХЗГ-ын замын барилгын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга



Х.ГАНБОЛД

Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн




Н.БАЯРСАЙХАН

Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааы төвийн орлогч захирал



Ха.ГАНТӨМӨР

Зам, тээврийн яамны АЗБХЗГ-ын Замын барилгын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн



Д.ЭНХТУЯА

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

“Эн Би Си Си” ХХК-ний Ерөнхий инженер



С.ГАНХУЯГ

**МЯНГАНЫ ЗАМ ТӨСЛИЙН ХЭВТЭЭ ТЭНХЛЭГИЙН УЛИАСТАЙ-ХОВД ЧИГЛЭЛИЙН
ДӨРВӨЛЖИН /ЭРДЭНЭХАЙРХАН/ -САРХАЙРХАН ЧИГЛЭЛИЙН 160.2 КМ АВТО
ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ
ДҮГНЭСЭН АКТ**

2012 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

Дөрвөлжин /Эрдэнэхайрхан/ – Сархайрхан чиглэлийн 160.2км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 365 700 000.0 (гурван зуун жаран таван сая) төгрөгөөр гүйцэтгэхээр 2012 оны 05 дугаар сарын 05-ний өдөр гэрээ байгуулсан.

Уг ажлыг Авто замын газрын баталсан зураг төсөл зохиох техникийн даалгаварын дагуу хийж гүйцэтгэсэн, улсын эксперт Монгол улсын зөвлөх инженер Я.Баярхүү экспертизээр баталгаажуулж захиалагчид хүлээлгэн өгөв.

Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдэл:

- | | |
|--|--|
| • Ажлын зураг /иж бүрдэл / | 4% (28 дэвтэр) |
| • Тайлбар бичиг | 4% (4 дэвтэр) |
| • Техникийн шаардлага | 4% (4 дэвтэр) |
| • Хучилтын тооцоо | 4% (4 дэвтэр) |
| • Ус өнгөрөөх байгууламжийн тооцоо,
судалгааны тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Архилогийн тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Инженер геологийн судалгаа | 4% (24 дэвтэр) |
| • Геодизийн тайлан | 4% (8 дэвтэр) |
| • Байгаль орчны үнэлгээний тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Барилгын ажлын төсөв | 1% (1 дэвтэр) битүүмжилсэн
байдлаар |
| • CD | 2% |


Гэрээт ажлыг хугацаанаас 20 хоног хоцроосон тул гэрээний 3.8 дугаар зүйлд заасны дагуу 18,285,000.0 төгрөгийн алданги ноогдуулж байна. Зураг төслийн ажлын эцсийн санхүүжилт буюу 365,700,000.0₮ – 109,710,000.0₮ (Дунд шатны тайлангийн санхүүжилт) = 255,990,000.0₮ 237,705,000.0₮ (гэрээний үнийн 65%) - 18,285,000.0₮ (алданги) = 219,420,000.0₮ (хоёр зуун арван есөн сая дөрвөн зуун хорин мянга) төгрөг болно.

Захиалагчийг төлөөлж:

Зам тээврийн яамны АЗБХЗГ-ын Замын барилгын үйлдвэрлэлийн хэлтэсийн дарга

 Х.ГАНБОЛД

Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэсийн мэргэжилтэн

 Н.БАЯРСАЙХАН

Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төвийн орлогч захирал

 Х.ГАНТӨМӨР

АЗБХЗГ-ын Замын барилгын үйлдвэрлэлийн хэлтэсийн мэргэжилтэн

 Д.ЭНХТУЯА

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Эн Би Си Си” ХХК-ний захирал

 О.ЧИНЗОРИГ


“Эн Би Си Си” ХХК-ний ерөнхий инженер


 С.ГАНХУЯГ


**МЯНГАНЫ ЗАМ ТӨСЛИЙН ХЭВТЭЭ ТЭНХЛЭГИЙН УЛИАСТАЙ-ХОВД ЧИГЛЭЛИЙН
 ДӨРВӨЛЖИН-САРХАЙРХАН ЧИГЛЭЛИЙН 159КМ АВТО ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН
 ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
 №02**

Гүйцэтгэгч: “Эн Би Си Си” ХХК

№	Зардлын нэр	Үндэслэл	Нийт үнэ /төг/
	Шууд зардал		
1	Замын хайгуул	БД 81-104-04	52,274,867.7
2	Замын зураг төсөл	БД 81-104-04	78,412,301.6
	ДҮН		130,687,169.3
1	Экспертизийн зардал 4%		5,227,486.8
2	Норм, нормативын сан 0.18%		235,236.9
3	Захиалагчийн зардал 2%		2,613,743.4
4	НӨАТ 10%		13,138,233.8
	ДҮН		152,640,000.0
1	Инженер геологийн судалгаа, тайлан	Үнийн санал	76,320,000.0
2	Геодезийн байр зүйн зураг, тайлан	Үнийн санал	108,120,000.0
	НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /Гэрээний үнийн дүн/		365,700,000.0
	Өмнөх гүйцэтгэлийн дүн 30%		109,710,000.0
	Баталгаат хугацааны 5%		18,285,000.0
	ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН 65%		237,705,000.0
	АЛДАНГИ		18,285,000.0
	ГҮЙЦЭТГЭГЧИД САНХҮҮЖҮҮЛЭХ ДҮН /гүйцэтгэлийн дүнгээс алданги хассан дүн/		219,420,000.0

Захиалагчийг төлөөлж
 Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын
 хэлтсийн дарга
 **З.ЦЭРЭНЧИМЭГ**

Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын
 хэлтсийн мэргэжилтэн
 **Н.БАЯРСАЙХАН**

Зам, тээврийн яамны АЗБХЗГ-ын Зам барилга
 үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
 **Х.ГАНБОЛД**

Гүйцэтгэгчийг төлөөлж
 “Эн Би Си Си” ХХК-ний
 Захирал
 **О.ЧИНЗОРИГ**

“Эн Би Си Си” ХХК-ний
 Ерөнхий инженер
 **С.ГАНХУЯГ**

Авто замын хяналт, эрдэм шинжилгээ,
 Судалгааны төвийн орлогч захирал

 **Х.ГАНТӨМӨР**

Зам, тээврийн яамны Замын барилгын
 үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

 **Д.ЭНХТУЯА**

**МЯНГАНЫ ЗАМ ТӨСЛИЙН ХЭВТЭЭ ТЭНХЛЭГИЙН УЛИАСТАЙ-ХОВД ЧИГЛЭЛИЙН
ДӨРВӨЛЖИН /ЭРДЭНЭХАЙРХАН/ -САРХАЙРХАН ЧИГЛЭЛИЙН 160.2 КМ АВТО
ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ ХҮЛЭЭН АВСАН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2012 оны 10 дугаар сарын-ны өдөр

Улаанбаатар хот

Хурлыг Зам, тээврийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын барилга үйлдвэрлэлийн хэлтсийн 411 тоот албан ерөөнд хийв. Хуралд Замын барилга үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Х.Ганболд, Замын барилга үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Д.Энхтуяа, "Эн Би Си Си" ХХК-ий ерөнхий инженер нар байлцав.

Хурлыг 11.00 цагаас эхэлж, 11.20 цагт дуусгав.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Дөрвөлжин /Эрдэнэхайрхан/ - Сархайрхан чиглэлийн 160.2 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл" хүлээн авсан тухай

ХЭЛЭЛЦСЭН нь:

Д.Энхтуяа - "Дөрвөлжин /Эрдэнэхайрхан/ - Сархайрхан чиглэлийн 160.2 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл"-ийг Захиалагч ЗТБХБЯ /хуучин нэрээр/, Санхүүжүүлэгч Хөгжлийн банк, Гүйцэтгэгч "Эн Би Си Си" ХХК-ий хооронд 2012 оны 5 дугаар сарын 21-ний өдөр 365 700 000.0 төгрөгөөр байгуулсан.

Уг чиглэлийн нарийвчилсан зураг төсөлд Улсын эксперт Монгол Улсын Зөвлөх инженер Я.Баярхүү магадлал хийж дүгнэлтийг гарган, зохих засварыг оруулж, баталгаажуулсан байна.

Гэрээ болон батлагдсан зургийн даалгаварт заасны дагуу доорх иж бүрдлийг Захиалагчид хүлээлгэн өгсөн болно. Үүнд:

- | | |
|---|----------------|
| • Ажлын зураг /иж бүрдэл / | 4% (28 дэвтэр) |
| • Тайлбар бичиг | 4% (4 дэвтэр) |
| • Техникийн шаардлага | 4% (4 дэвтэр) |
| • Хучилтын тооцоо | 4% (4 дэвтэр) |
| • Ус өнгөрөөх байгууламжийн тооцоо, судалгааны тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Архилогийн тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Инженер геологийн судалгаа | 4% (24 дэвтэр) |
| • Геодизийн тайлан | 4% (8 дэвтэр) |
| • Байгаль орчны үнэлгээний тайлан | 4% (4 дэвтэр) |
| • Барилгын ажлын төсөв битүүмжилсэн байдлаар | 1% (1 дэвтэр) |
| • CD хүлээлгэн өгсөн. | 2% -г тус тус |

Гүйцэтгэгч "Эн Би Си Си" ХХК нь "Дөрвөлжин /Эрдэнэхайрхан/ - Сархайрхан чиглэлийн 160.2 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл"-ийг 2012 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Магадлал хийлгэн хүлээлгэн өгсөн юм.

Гэрээнд заасны дагуу инженерийн нарийвчилсан зураг төслийг 2012 оны 9 дүгээр сарын 7-нд хүлээлгэн өгөхөөр заасан байгаа.

С.Ганхуяг - Бид гэрээнд зураг төслийн ажлыг 2012 оны 05 сарын 05-ны өдрөөс эхэлж 2012 оны 9 дүгээр сарын 7-ний өдөр дуусгаж захиалагчид хүлээлгэн өгөхөөр тайлан

гаргах хуваарийг хийсэн. Гэтэл гэрээ байгуулагдсанаас хойш авто замын зураг төслийн иж бүрдэл болох байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэхээр хуучинаар Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүсэлт хүргүүлсэн боловч тус яамнаас Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөн, яамны нэр, бүтэц өөрчлөгдөж байгаатай холбогдуулан байгаль орчны үнэлгээний дүгнэлтийг хойшлуулсаар 2012 оны 09 дугаар сарын 28-ны өдөр батлаж манай ирүүлсэн учир ажил дуусгаж, хүлээлгэн өгөх хугацаа 21 хоногоор хойшилсон юм.

2012 оны 10 дүгээр сарын 05-ны өдөр дуусган улсын эксперт томилуулах хүсэлтээ албан тоотор Зам, тээврийн яаманд хүргүүлсэн юм.

Зам, тээврийн яамнаас 2012 оны 10 дугаар сарын 10-ний өдөр магадлал хийлгэхээр эксперт Монгол Улсын зөвлөх инженер Я.Баярхүүг томилсоны дагуу зураг төслийг хүлээлгэн өгсөн. Магадлалын дүгнэлтийг 2012 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч, зураг төсөлд зохих засварыг хийж, 10 дугаар сарын 18-ны өдөр Экспертэд шалгуулан зөвшөөрүүлж дүгнэлтийн хариуд гарын үсэг зурсан юм.

Ингээд инженерийн нарийвчилсан зураг төслийг 10 дугаар сарын 18-нд Зам, тээврийн яаманд хүлээлгэн өгсөн.

Д.Энхтуяа - "Дөрвөлжин /Эрдэнэхайрхан/ - Сархайрхан чиглэлийн 160.2 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл"-ийг дуусгах гэрээт хугацаа 2012 оны 9 дүгээр сарын 07-ний өдөр байсан юм. Инженерийн нарийвчилсан зураг төсөл иж бүрдэл болох Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас 2012 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр гаргаж ирүүлсэн. Гэрээт хугацаа 21 хоногоор хойшилсон гэж үзээд, гэрээний хугацааг 20 өдрөөр хоцроосон ба 2012 оны 10 дугаар сарын 18-ний өдөр хүлээлгэн өгсөн.

Гэрээний тусгай нөхцөлийн 3.8-д заасны дагуу алдангийг тооцож үзэхэд 18,285,000.0 төгрөг болж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. "Дөрвөлжин /Эрдэнэхайрхан/ - Сархайрхан чиглэлийн 160.2 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл"-ийг батлагдсан зургийн даалгаврын дагуу боловсруулж дуусгасан бөгөөд нарийвчилсан зураг төслийг боловсруулах гэрээт хугацааг хоцроосон 20 хоногт алдангийг тооцож 18,285,000.0 төгрөгийг санхүүжилтийн дүнгээс хасч тооцох нь зүйтэй гэж үзлээ.

2. Цаашид гүйцэтгэх инженерийн нарийвчилсан зураг төслийн ажлыг гэрээт хугацаандаа багтаан хийж байхыг анхааруулав.

Хурлын тэмдэглэлтэй танилцаж зөвшөөрсөн:

Зам, тээврийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын барилга үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Х.ГАНБОЛД

"Эн Би Си Си" ХХК-ий ерөнхий инженер

С.ГАНХУЯГ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын барилга үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

Д.ЭНХТУЯА

ТООЦООНЫ ҮЛДЭГДЛИЙН БАТАЛГАА № 74

Нэхэмжлэгч:	Хариуцагч:
Байгууллагын нэр: _____ Эн Би Си Си ХХК	Байгууллагын нэр: _____ Зам, тээврийн хөгжлийн яам
Хаяг: _____	Хаяг: _____
Утас, факс: _____	Утас, факс: _____
Э-шуудан: _____	Э-шуудан: _____
Банкны нэр: Голомт банк	Банкны нэр: Төрийн сан
Банкны дансны дугаар: 1102906774	Банкны дансны дугаар: 100900028350

ТООЦОО НИЙЛСЭН ДАНСНЫ №: 41362

Нэхэмжлэгчийн нэрийн өмнөөс _____ захирал _____ ажилтай _____ О. _____ овогтой _____ Чинзориг _____ нь төлөгчийн нэрийн өмнөөс _____ нягтлан бодогч _____ ажилтай _____ Ооёо _____ овогтой _____ Очгэрэл _____ -тай тус хоёр байгууллага хооронд _____ 2021 оны 1 сарын 1 өдрөөс _____ 2021 оны 12 сарын 31 өдрийг дуустал хугацаанд өгч авалцсан зүйлээ хоёр байгууллагад хөтлөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэлийн бичилтээр нэг бүрчлэн нийлж үзэхэд _____ Зам, тээврийн хөгжлийн яам _____ (төлөгчийн нэр) _____ арван найман сая хоёр зуун наян таван мянган _____ төгрөг _____ 00 мөнгө _____ нь _____ 18,285,000.00 _____ төгрөг _____ -ийн _____ (үсгээр)

өртэй гарсныг харилцан батлав.

Энэхүү өрийн үлдэгдлийг _____ тооцооны хэлбэрээр нэхэмжлэн авахаар тохиролцов.

(Тэмдэг) Нэхэмжлэгч байгууллагын нягтлан бодогч :..... /О.Чинзориг/
 (Тэмдэг) Хариуцагч байгууллагын нягтлан бодогч :..... /О.Очгэрэл/



Тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралт

/төгрөгөөр/

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	Барьцаа хөрөнгийн 2021 оны эхний үлдэгдэл	2021 оны орлого	2021 оны зарлага	Барьцаа хөрөнгийн 2021 оны эцсийн үлдэгдэл
371	Дөрвөлжин-сархайрхан 159 км замын зураг	"Эн Би Си Си" ХХК	18,285,000.00			18,285,000.00

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2013 оны 01 дугаар
сарын 08 өдөр

Дугаар 29/2013

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: 976-11-320338

Объектын нэр:	Завхан аймгийн Сархайрхан-Эрдэнэхайрхан чиглэлийн 160.3 км хатуу хучилттай замын инженерийн нарийвчилсан зураг төсөл		
Объектын байршил:	Завхан аймгийн Дөрвөлжин, Завханмандал сум		
Хүчин чадал:	160.3 км хатуу хучилттай авто зам		
Захиалагч:	Зам, тээврийн яам		
Санхүүжилтийн эх үүсвэр:	Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар		
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр,	"Эн Би Си Си" ХХК		
Регистрийн дугаар:	РД:5102227		
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2014.05.11 хүртэл		
Ажилбарын төрөл:	1.3.1, 1.3.3		
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	Завхан аймгийн Дөрвөлжин сумын Засаг даргын 2011.11.02-ны өдрийн № 69 тоот захирамж, Завхан аймгийн Завханмандал сумын Засаг даргын 2011.10.31-ний өдрийн № 40 тоот захирамж		
<u>Зураг төсөл боловсруулах үндэслэл:</u>			
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Авто замын газрын дарга Б.Энхтөрийн 2011.04.26-ны өдөр баталсан № 50/11 тоот зургийн даалгавар		
Зураг төслийн гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Монгол улсын Хөгжлийн банк, "Эн Би Си Си" ХХК-ийн хооронд байгуулсан 2012.05.04-ний өдрийн №САЗБ-2012/03 тоот гэрээ		
<u>Техникийн нөхцлүүд:</u>			
Техникийн нөхцлүүд:	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
Гадна цахилгаан :	-	-	-
Гадна холбоо :	-	-	-
<u>Зөвшөөрөлцсөн байгууллагууд:</u>			
Завхан аймгийн Дөрвөлжин сумын засаг дарга		З.Бадмаа	

Завхан аймгийн Завханмандал сумын засаг дарга		Д.Бямбацогт	
Зураг төслийн бүрэлдэхүүн:			
Зургийн бүрдэл:	Дугаар, хуудасны тоо:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр	Шалгасан экспертний нэр
Ажлын зургийн тайлбар бичиг	A4 формат 1 дэвтэр	"Эн Би Си Си" ХХК	Я.Баярхүү
Үндсэн зураг	A3 формат 1 дэвтэр	"Эн Би Си Си" ХХК	Я.Баярхүү
Хиймэл байгууламжийн зураг	A3 формат 1 дэвтэр	"Эн Би Си Си" ХХК	Я.Баярхүү
Хөндлөн огтлолын зураг	A3 формат 5 Дэвтэр	"Эн Би Си Си" ХХК	Я.Баярхүү
Техникийн шаардлага	A4 формат 1 дэвтэр	"Эн Би Си Си" ХХК	Я.Баярхүү
Хучилтын тооцоо	A4 формат 1 дэвтэр	"Эн Би Си Си" ХХК	Я.Баярхүү
Ус өнгөрүүлэх байгууламжийн тооцоо	A4 формат 1 дэвтэр	"Эн Би Си Си" ХХК	Я.Баярхүү
Барилгын ажлын төсөв	A4 формат 1 дэвтэр	"Эн Би Си Си" ХХК	Да.Энхтуяа
Геотехникийн судалгаа	A3 формат 2 дэвтэр A4 формат 4 дэвтэр	"Эко тех проект" ХХК	Дүгнэлт баталгаажсан
Ерөнхий дүгнэлт:			
<i>/Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлээс/</i>			
Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;	<p>Барилга байгууламжийн хүчин чадал: Завхан аймгийн Сархайрхан-Эрдэнэхайрхан чиглэлийн 160.3 км асфальтобетон хучилттай авто замын 123 цэгт төмөр бетон хиймэл байгууламж төлөвлөсөн нь холбогдох норм дүрмийн шаардлага хангасан гэж эксперт дүгнэсэн байна.</p> <p>Төлөвлөлт: Төлөвлөж буй зам нь 160.3 км урттай, далангийн өргөн 11,0 метр, 7.0 метрийн өргөн зорчих хэсэгтэй, 2.0 м өргөн хөвөөний 0.5 метр нь бэхэлгээтэй, Өнгө асфальтобетон хучилт - 30 мм Суурь асфальтобетон хучилт - 40 мм Цементээр бэхжүүлсэн суурь - 150 мм Суурийн доод үе - 150 мм Далангийн дээд үе - 300 мм Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцлийг хангасан шийдлийг тусгах шаардлагагүй гэж үзсэн байна.</p> <p>Техник технологи, дэд бүтцийн хангамж "Эко тех проект" ХХК-нд 2012 онд боловсруулсан инженер геологийн судалгааны дүгнэлтээр газар хөдлөлийн 9</p>		

	баллын бүсэд хамрагдана. Трассын дагуу ерөмдсөн цооногуудад хөрсний ус 1.0 м – 4.0 м хүртэлх гүнд илэрсэн байна.
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт;	Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдлийг орон тооны бус эксперт шалгаад: Төлөвлөж буй авто зам нь ус зайлуулах байгууламжийн төлөвлөлтөнд буюу дугуй хоолойн ул хөрсөн дээр бетоноор суурь цутгахаар төлөвлөсөн болон тулц хана дөрвөлжин хоолойн дор тэгшилгээний бетон төлөвлөснийг өөрчлөх зэрэг алдаа зөрчлүүд гарсныг нэмэлт өөрчлөлтөөр засах, мөн техникийн шаардлагад ганцхан хольцын шаардлага тавигдсан байгааг засч, хучилтыг 2 үе суурь болон өнгө асфальтобетоноор хийхээр тусгасныг зураг төсөлтэй уялдуулах, битумэн түрхлэгт тавигдах шаардлагыг нэмж тусгах зэрэг засваруудыг санал дүгнэлтэд тусгасныг засах арга хэмжээг авсан байна.
Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаархи дүгнэлт.	Монгол улсын Эдийн засаг, нийгмийн бэрхшээлтэй асуудлыг цогцоор нь шийдэх, Хөгжлийг жигд хангах, Хүн амын эрүүл, аюулгүй нөхцөлд амьдрах эрхийг нь баталгаажуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2001 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай" 9 дүгээр тогтоол, 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай 36 дугаар тогтоолоор баталсан авто замын чиглэлүүдэд Улиастай – Ховд чиглэлийн авто замын чиглэл тусгагдсан байдаг. Тус чиглэлийн авто зам нь баруун бүсийн Ховд, Баян-Өлгий аймгуудыг Улиастай, Цэцэрлэг, Мөрөн, Булган, Улаанбаатар зэрэг төвийн бүсийн томоохон хотуудтай холбож байгаа нь бүс нутгийн аялал жуулчлал, дотоодын тээврийн хөдөлгөөн нэмэгдэх бөгөөд Дөрвөлжин /Эрдэнэхайрхан/ - Сархайрханы замын трассын дагууд цайны газар, дугуй засвар, шатахуун түгээх станц зэрэг үйлчилгээний цэгүүд бий болж, улмаар орон нутгийн ажилгүй иргэдэд байнгын ажлын байр бий болох эдийн засгийн үр ашигтай. Хатуу хучилттай авто зам барьсанаар хуучин хөрсөн замууд байгалийн унаган төрхөндөө орох нөхцөл бололцоо бүрдэнэ.
Барилгын ажлын төсөв	"Завхан аймгийн Сархайрхан-Эрдэнэхайрхан чиглэлийн 160.3 км хатуу хучилттай замын барилгын ажлын төсөв"-ийг орон тооны бус эксперт 97 411 075 166 (Ерэн долоон тэрбум дөрвөн зуун арван нэгэн сая далан таван мянга нэг зуун жаран зургаан төгрөг)-өөр хянасан байна.

“Барилгын тухай” хуулийн 13.4-т заасны дагуу “Зураг төсөл зохиогчийн гаргасан алдааг зураг төслийн байгууллага, зохиогч хариуцах ба магадлал хийсэн этгээд зураг төслийн техникийн шийдлийн талаар гаргасан дүгнэлтийнхээ төлөө хариуцлагыг хүлээнэ.”

Завхан аймгийн Сархайрхан-Эрдэнэхайрхан чиглэлийн 160.3 км хатуу хучилттай замын инженерийн нарийвчилсан зураг төсөлд “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”-ийн дагуу магадлал хийгдэж, холбогдох норм ба дүрмийн шаардлага хангасан байна.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь экспертүүдийн хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ

ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.БАЯРСАЙХАН

Л.БАЯРСАЙХАН

Д.ЭНХТУЯА

Д.БАТБААТАР

Завхан аймгийн Сархайрхан-Эрдэнэхайрхан сум чиглэлийн 160,3 км хатуу хучилттай авто зам.

- Гүйцэтгэгч "Эн Би Си Си" ХХК
 - Зургийн иж бүрдэл:
 - Тайлбар бичиг
 - Үндсэн зураг
 - Хиймэл байгууламжын зураг
 - Хөндлөн огтлолын зураг
 - Техникийн шаардлага
 - Хучилтын тооцоо
 - Ус өнгөрүүлэх байгууламжын тооцоо
 - Геодизийн хэмжилт, зураглалын ажлын тайлан
 - Геотехникийн судалгаа
 - Археологийн хайгуулын тайлан
 - Төсөвт өртөг

Дүгнэлтийн утга
<p>Завхан аймгийн Сархайрхан-Эрдэнэхайрхан сум чиглэлийн 160,3 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөлд шүүлт хийж доорх дүгнэлтийг гаргав. Үүнд:</p> <p>А. Зураг төслийн иж бүрдэл</p> <p>Зураг төслийг ерөнхий гүйцэтгэгч "Эн Би Си Си" ХХК, инженер геодезийн хэмжилтийг туслан гүйцэтгэгч "Бэйс Пойнт" ХХК, инженер геологи материалын судалгааг туслан гүйцэтгэгч "Эко тех проект" ХХК тус тус гүйцэтгэсэн байна.</p> <p>1. Ажлын даалгаварт заагдсан иж бүрдэлээс Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ ирүүлээгүй.</p> <p><u>В. Геодизийн хэмжилт судалгаа</u></p> <p>Геодизийг Балтийн тэнгисийн өдрийн тогтолцоо, координатын UTM систем, WGS 84 ашиглан хэмжилт судалгааг хийжээ.</p> <p>1. Геодизийн байнгийн цэг 87 –г шинээр болон шинэчлэн байгуулсан байна. Энэ нь ажлын даалгаварт заагдсан /2км тутамд репер байгуулах/ шаардлагад нийцсэн байна.</p> <p>2. Геодизийн хэмжилтийн тайлангийн дүгнэлтэнд "Уг ажлыг хийж гүйцэтгэхэд өндрийн сүлжээний цэг олддоогүй, олдсон нь трассын эхлэл төгсгөлүүдээс хол байсан" гэсэн байна. Энэ юу гэсэн үг вэ? Геодизийн хэмжилт алдаатай байх магадлалтай гэсэн үг үү. Тийм бол энэ зураглалаар замын ажил гүйцэтгэж болох уу?</p> <p><u>Г. Геологийн судалгаа</u></p> <p>1. Трассын дагуу 215 цооног, ус зайлуулах байгууламжын дагуу 106 цооног, үе шатны ажилд хэрэглэгдэх нөөц газрын 24 цооног өрөмдөж геологийн судалгаа</p>

хийжээ. Энэ нь уг замын геологийн судалгаа хийхэд хангалттай дээжлэлт болжээ гэж үзэж байна

2. Лабораторийн туршилт шинжилгээ хийсэн тайланд шинжилгээний аргачлалыг ASTM стандартаар хийсэн тухай бичсэн байна. Эдгээр стандартууд нь Монгол хэлнээ хөрвүүлэгдэн үндэсний стандарт болсоныг анхаарч /MNS/ үндэсний стандартын дугаарыг бичих.
3. Лабораторийн туршилт шинжилгээнд зарим дээжийн ХҮХИН нь 2,3 гр/см³ дээш гарсан байна. Яагаад вэ?

Д. Археологийн хайгуулын тайлан

Археологийн тандалт, хайгуулын судалгааг "Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн"-гээр хийж гүйцэтгүүлсэн байна.

- Трассын дагуу 90-ээд түүхийн дурсгалын цэг байгаагаас 5 нь замын трасст, 10 нь карьер авах талбайд өртөж байгааг судалгааны тайланд дурдсан байна. Эдгээр түүхийн дурсгалыг авран хамгаалах ажлын төсвийг тооцон /54 855 500,0 төгрөг/ гаргасан байна. Энэ нь ажлын даалгаварт заагдсаны дагуу болжээ гэж үзэж байна.

Е. Хучилтын тооцоо

Хучилтын тооцоог AASHTO-гийн аргачлалын дагуу, одоо байгаа тээврийн хэрэгсэлийн эрчим түүний өсөлттэй уялдуулан 20 жилийн дараах ESAL-аар тооцож SN=2,517 гаргасан байна. Үүнийг ажлын даалгаварын онцгой нөхцөлд заасаны дагуу хучилтын хийцийн хамгийн бага нөхцөлтэй харьцуулахад /SN=2.835/ хангаж байгаа тул хучилтын хийцийг "Монгол орны асфальтбетон хучлагатай авто замын хучилтын хийцийн жишиг цомог"-ийн дагуу

- Асфальтбетон өнгө 3 см
- Суурь асфальтбетон 4 см
- Цементээр бэхжүүлсэн суурь 15см
- Хайгаар хийсэн суурь 15см байхаар тооцож гаргасан нь ажлын даалгаварт заагдсаны дагуу тооцож гаргасан байна.

Ж. Тайлбар бичиг

1. Ажлын тоо хэмжээнд тусгасан үйлдвэрлэлийн зохион байгуулалт, лабораторийн туршилт шинжилгээний ажил, завод тоног төхөөрөмж угсарах ажлуудыг хасах. Энэ нь ажлын нэгж зардалд /төсөв зохиох программ/ суусан байдаг.
2. Ажлын тоо хэмжээнд /АТХ/ цемент болон шохойгоор суурь бэхжүүлэх тухай заасаныг тодруулах зураг төсөлтэй уялдахгүй, шохойг хасах.
3. АТХ-д халуун хольцоор хучилт байгуулах тухай 2 заалт байгааг тодотгох. Зураг төсөлд өнгө болон суурь асфальт бетон төлөвлөснийг анхаарах.
4. АТХ-д археологийн тандалт малталтын ажлын зардлыг тусгах /томсгосон үнээр/
5. АТХ-д шингэн цацлагын хэмжээг 128708 м² гэснийг дахин шалгах /1 300 000,0м² орчим гарах ёстой/
6. АТХ-д битум нь түрхлэгийн /таск соат/ хэмжээг тусгаагүй байна.
7. АТХ-д замын тэмдэглэгээний хэмжээг 372701 м гэсэн байна. Үүнд бэхжүүлсэн /paved shoulder/ хөвөөгөөр татах тэмдэглэгээний хэмжээ орсон уу?

З. Ажлын зураг

1. Хиймэл байгууламжын зурагт:

- a. дугуй хоолойн төлөвлөлтөнд ул хөрсөн дээр бетоноор суурь цутгахаар төлөвлөсөн байгааг өөрчилж ул хөрсөн дээр элс хайрган эсвэл буталсан чулуун дэвсгэр үе байгуулсаны дараа суурь бетон цутгахаар төлөвлөх.
- b. тулц хана, дөрвөлжин хоолойн доор тэгшилгээний бетон төлөвлөснийг өөрчилж элс хайрган эсвэл буталсан чулуун дэвсгэр үе төлөвлөх, бетоны доор бетонон тэгшилгээний үе төлөвлөлдөг /ул хөрсөн дээр/ ийм аргачлал байдгүйг онцгой анхаарах
2. Хиймэл байгууламжын зурагт ажлын тоо хэмжээг нэмж тусгах,
3. Хөлдөлтөөс хамгаалах үеийг ажлын зурагт төлөвлөсөн байна. Трассын дагуух газар нутаг нь зам цаг уурын III А бүсэд хамаарагдаж байгаа тул "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН-01.01-2004 стандартын дагуу хүйтэнээс хамгаалах үеийг төлөвлөх шаардлагагүй /трассын дагуух геологийн судалгааг үзэх/ гэж үзэж байна.
4. Дэвсгэр зурагт трассын дагуу тасархай болон үргэлжилсэн хар өнгөтэй шугам зурагдсан байна. Энэ юуг тэмдэглэсэн вэ? Тэмдэглэгээнд тайлбар бичих.
5. Хучилтын өргөсөлт болон амрах талбай байгуулж буй хэсгийн байршил болон бусад шаардлагатай өгөгдлийн хураангуйг ажлын зурагт тусгах

И. Техникийн шаардлага

1. Хучилтыг 2 үе суурь болон өнгө асфальтаар хийхээр зураг төсөлд тусгасан. Гэтэл ТШ-ийн 1200-д ганцхан /том, жижиг аль нь вэ?/ хольцын шаардлага тавигдсан байгааг зураг төсөлтэй уялдуулаж ТШ-ийг өөрчлөлт оруулах
2. Хүйтэнээс хамгаалах үед тавигдсан шаардлагыг хасах /хэрвээ үлдээх шаардлагатай бол уян налархайн индексийг NP болгох/
3. Битумэн түрхлэгэд тавигдах шаардлагийг нэмж тусгах

Ерөнхий дүгнэлт

1. Боловсруулсан баримт бичгийн иж бүрдэлийг ажлын даалгаварт заагдсаны дагуу /Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнээс бусад/ хийж гүйцэтгэсэн байна. Ялангуяа хучилтын тооцоо, архелогийн урьдчилсан тандалт малталтын ажлын тайлан зэргийг хийж ирүүлсэн нь сайшаалттай байна.
2. Зураг төслийн инженерийн зарим шийдэл дээр сайн төвлөрч ажиллаагүйгээс зарим нэг алдаа дутагдал гаргасан байна.

Иймд дээрх шүүмжийн дагуу зураг төслийн холбогдох баримт бичгийг засварлан эцэслэсний дараа гарын үсэг зуруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Дүгнэлт бичсэн: Эксперт **БАЯРХҮҮ**




УЛСЫН ЭКСПЕРТИЗИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАРИУ


Завхан аймгийн Сархайрхан-
 * Эрдэнэмандал чиглэлийн 160.3 км хатуу
 хучилттай авто замын нарийвчилсан зураг
 төсөл

"ЭН БИ СИ СИ" ХХК


2012

No	Экспертизийн дүгнэлт	Экспертизийн дүгнэлтийн хариу
1.	Геодизийн хэмжилтийн тайлангийн дүгнэлтэнд "Уг ажлыг хийж гүйцэтгэхэд өндрийн сүлжээний цэг олддоогүй, олдсон нь трассын эхлэл төгсгөлүүдээс хол байсан" гэсэн байна. Энэ юу гэсэн үг бэ? Геодизийн хэмжилт алдаатай байх магадлалтай гэсэн үг үү? Тийм бол энэ зураглалаар замын ажил гүйцэтгэж болох уу?	Геодезийн хэмжилтийн тайлангийн дүгнэлт утгын хувьд буруу бичигдсэн хигдсэн байсныг залруулав. Геодезийн хэмжилтийн ажилд улсын өндрийн Рп-3737 болон Хм-3140 цэгүүдийг ашигласан болно. Авто замын геодезийн хэмжилт, зураглалын ажлын тайлан хуудас-1-ээс үзнэ үү. Уг зураг төслөөр зам барилгын ажил гүйцэтгэхэд ямар нэгэн асуудал гарахгүй болно.
2.	Лабораторийн туршилт шинжилгээ хийсэн тайланд шинжилгээний аргачлалыг ASTM стандартаар хийсэн тухай бичсэн байна. Эдгээр стандартууд нь Монгол хэлнээ хөрвүүлэгдэн үндэсний стандарт болсныг анхаарч /MNS/ үндэсний стандартын дугаарыг бичих	Үндэсний стандартын дугаарыг бичиж залруулав.
3.	Лабораторийн туршилт шинжилгээнд зарим дээжийн ХҮХИН нь 2.3 гр/см ³ дээш гарсан байна. Яагаад вэ?	Хэвний эзэлхүүнийг 2176 см ³ байсныг лабораторын туршилтын үед 1969 см ³ болгож алдаа гаргасныг 2176 см ³ болгон засварлалаа. Ингэснээр ХҮХИН нь 2.3 гр/см ³ доош гарсан.
4.	Ажлын тоо хэмжээнд тусгасан үйлдвэрлэлийн зохион байгуулалт, лабораторийн туршилт шинжилгээний ажил, завод тоног төхөөрөмж угсрах ажлуудыг хасах. Энэ нь ажлын нэгж зардалд /төсөв зохиох программ/ суусан байдаг.	Ажлын тоо хэмжээг авто зам төлөвлөх RD программаас гарсан тоо хэмжээг оруулж хавсаргав.
5.	Ажлын тоо хэмжээнд цемент болон шохойгоор суурь бэжжүүлэх тухай заасныг тодруулах зураг төсөлтэй уялдахгүй, шохойг хасах	Цементээр бэжжүүлсэн суурь болгон залрууллаа.
6.	Ажлын тоо хэмжээнд халуун хольцоор хучилт байгуулах тухай 2 заалт байгааг тодотгох. Зураг төсөлд өнгө болон суурь асфальтбетон төлөвлөснийг анхаарах	Ажлын тоо хэмжээг авто зам төлөвлөх RD программаас гарсан тоо хэмжээг оруулж хавсаргав. Засварлалаа.
7.	Ажлын тоо хэмжээнд археологийн тандалт малталтын ажлын зардлыг тусгах /томсгосон үнээр/	Ажлын тоо хэмжээнд археологийн тандалт, малталтын ажлын тоо хэмжээг оруулаа. Мөн археологийн тандалт малталтын ажлын зардлыг төсөвт суулгаж өгсөн болно.



8.	Ажлын тоо хэмжээнд шингэн цацлагын хэмжээг 128708 м2 гэснийг шалгах	Ажлын тоо хэмжээнд шингэн цацлагын хэмжээ буруу шивж оруулсныг 1'287'084м2 болгон залрууллаа.
9.	Ажлын тоо хэмжээнд битум түрхлэгийн хэмжээг тусгаагүй байна.	Ажлын тоо хэмжээнд битум түрхлэгийн хэмжээг тусгаж оруулав.
10.	Ажлын тоо хэмжээнд замын тэмдэглэгээний хэмжээсийг 372701 м гэсэн байна.Үүнд бэхжүүлсэн /paved shoulder/ хөвөөгөөр татах тэмдэглээний хэмжээс орсон уу?	Хучлагатай хөвөөгөөр татах замын хэвтээ тэмдэглэгээ 7.2 ажлын тоо хэмжээ орсон байгаа болно.
11.	Дугуй хоолойн төлөвлөлтөнд ул хөрсөн дээр бетоноор суурь цутгахаар төлөвлөсөн байгааг өөрчилж ул хөрсөн дээр элс хайрган эсвэл буталсан чулуун дэвсгэр үе байгуулсны дараа суурь бетон цутгахаар төлөвлөх ийм аргачлал байхгүйг онцгой анхаарах	Сүүлийн үеийн хоолойн барилгын ажлын туршлагаас харахад энгийн ул хөрстэй газар хоолойн бетон суурийг шууд цутгаж хийж байгаа аргачлалыг үндэс болгон хийсэн дугуй хоолойн тулц хананы доор 10 см зузаантай М-12 маркийн бетон тэгшилгээний үе төлөвлөсөнийг хассан болно.
12.	Тулц хана,дөрвөлжин хоолойн доор тэгшилгээний бетон төлөвлөснийг өөрчилж,элс хайрган эсвэл буталсан чулуун дэвсгэр үе төлөвлөх,бетоний доор бетонон тэгшилгээний үе төлөвлөдөг /ул хөрсөн дээр/ ийм аргачлал байхгүйг онцгой анхаарах	Доор дурьдсан шаардлагуудыг хангахын үүднээс тэгшилгээний бетон хийх шаардлагатай болсон.Үүнд: <ul style="list-style-type: none"> • Аливаа төмөрбетон хийцийн дор заавал тэгшилгээний бетон хийх шаардлагатай байдаг. • Ул хөрсөн дээр үзүүлэх ачааллыг жигд хуваарилах үүднээс • Арматур зангидах гадаргууг тэгш болгохын үүднээс
13.	Хиймэл байгууламжийн зурагт ажлын тоо хэмжээг нэмж тусгаж өгөх	Хиймэл байгууламжийн ажлын тоо хэмжээг тайлбар бичигт орууллаа.
14.	Хөлдөлтөөс хамгаалах үеийг ажлын зурагт төлөвлөсөн байна.Трассын дагуух газар нутаг нь зам цаг уурын III А бүсэд хамаарагдаж байгаа тул "Авто замын уур амьсгал,геотехникийн нөхцөл" АЗУАГН-01.01.2004 стандартын дагуу хүйтнээс хамгаалах үеийг төлөвлөх шаардлагагүй гэж үзэж байна./трассын дагуух геологийн судалгааг үзэх/	Замын төлөвлөлтийн программаас гарсан subgrade/далангийн дээд үеийг буруу орчуулсан байсныг нэг маягийн хөндлөн огтлолд засварлан оруулав. 
15.	Дэвсгэр зурагт трассын дагуу тасархай болон үргэлжилсэн хар өнгөтэй шугам зурагдсан байна.Энэ юуг тэмдэглэсэн бэ?Тэмдэглэгээнд тайлбар бичих	Одоо байгааг-өрдийн хөрсөн зам. Ажлын зурагт таних тэмдгийг оруулж өглөө.
16.	Хучилтын өргөсөлт болон амрах талбай байгуулж буй хэсгийн байршил болон бусад шаардлагатай өгөгдлийн хураангуйг ажлын зурагт тусгах	Хучилтын өргөсөлттэй хэсгийн байршил болон холбогдох мэдээлийг эргэцийн диаграмм дээр харгалзах өнцөг тус бүрээр орууллаа.Амрах талбайн байршил болон хэмжээсүүд Боть-1 хуудас-207-д байгаа болно.

17.	Хучилтыг 2 үе суурь болон өнгө асфальтаар хийхээр зураг төсөлд тусгасан. Гэтэл ТШ-ийн 1200-д ганцхан хольцийн шаардлага тавигдсан байгааг зураг төсөлтэй уялдуулж ТШ-д өөрчлөлт оруулах	Өнгө болон суурь асфальтбетонд тавигдах шаардлагыг ТШ-д орууллаа.
18.	Хүйтнээс хамгаалах үед тавигдсан шаардлагыг хасах /Хэрвээ үлдээх шаардлагатай бол уян налархайн индексийг NP болгох	Далангийн дээд үеийг хүйтнээс хамгаалах үеийн материалтай адил шаардлагатай материалаар барих боломжтой.
19.	Битумэн түрхлэгт тавигдах шаардлагыг нэмж тусгах	Битум түрхлэгт тавигдах шаардлагыг Техникийн Шаардлагад тусгаж орууллаа.



ДҮГНЭЛТ БИЧСЭН ЭКСПЕРТ: Я.БАЯРХҮҮ

"ЭН БИ СИ СИ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ: О.ЧИНЗОРИГ

ДҮГНЭЛТИЙН ХАРИУ БИЧСЭН: Б.ӨНӨБОЛД